



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/58/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Д.Цэцэгмаа Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaa_1961@yahoo.vom Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.2 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,

Баянхонгор аймаг, 64101

Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

2022.02.24. № 2/24

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Г.АЛТАНТУЯА ТАНАА

танай _____-ны № _____-т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\alban bichig\A4-toot.docx

005020428

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	43,092,778.83	55,017,597.83
33	АВЛАГА	18,460.31	18,460.31
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	18,460.31	18,460.31
35	БАРАА МАТЕРИАЛ	43,074,318.52	54,999,137.52
351	Түүхий эд материал	855,000.00	2,876,700.00
35130	Эм боох материал	855,000.00	2,876,700.00
354	Хангамжийн материал	42,219,318.52	52,122,437.52
35410	Бичиг хэргийн материал	2,740,869.00	4,371,269.00
35420	Аж ахуйн материал	31,954,115.00	37,099,815.00
35450	Барилгын засварын материал	960,000.00	4,134,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,564,334.52	6,517,353.52
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	367,526,465.37	363,080,124.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	367,526,465.37	363,080,124.86
392	Биет хөрөнгө	357,382,465.37	352,661,124.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	352,567,450.00	352,567,450.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,224,368.40	-18,081,753.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,921,372.73	28,410,972.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	-12,916,359.79	-15,189,017.82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,470,464.01	21,470,464.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,556,692.14	-16,607,296.34
39214	Бусад үндсэн хөрөнгө	409,400.00	409,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-288,801.04	-319,094.44
393	Биет бус хөрөнгө	10,144,000.00	10,419,000.00
39301	Програм хангамж	150,000.00	425,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-150,000.00	-150,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,144,000.00	10,144,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	410,619,244.20	418,097,722.69
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	395,832.00	395,832.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	395,832.00	395,832.00
413	Өглөг	395,832.00	395,832.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	395,832.00	395,832.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	410,223,412.20	417,701,890.69
51	Засгийн газрын хувь оролцоо	410,223,412.20	417,701,890.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	60,925,265.00	60,925,265.00
51101	Өмч: - төрийн	60,925,265.00	60,925,265.00
512	Хуримтлагдсан үр дүн	-9,978,134.86	-2,499,656.37
51210	Өмнөх үеийн үр дүн	-9,978,134.86	-9,978,134.86
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	7,478,478.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	359,276,282.06	359,276,282.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	410,619,244.20	418,097,722.69

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	403,261,632.00	371,067,772.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,020,972.00	476,750.00
120	Нийтлэг татварын бус орлого	64,020,972.00	476,750.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	64,020,972.00	00.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	64,020,972.00	476,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	339,240,660.00	370,591,022.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	307,423,100.00	316,069,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	307,423,100.00	316,069,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,360,160.00	21,669,040.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,263,000.00	21,669,040.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	97,160.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,457,400.00	32,852,082.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,457,400.00	32,852,082.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	331,313,946.98	363,589,293.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	331,313,946.98	363,589,293.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	305,212,632.82	314,143,521.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,277,061.53	222,848,171.00
210101	Үндсэн цалин	194,671,665.53	204,504,456.00
210104	Урамшуулал	17,605,396.00	18,343,715.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,007,294.00	28,311,515.00
210201	Тэтгэврийн даатгал	18,088,358.00	20,060,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,122,738.00	2,228,482.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,689,342.00	1,783,460.00
210204	Ажилгүйдлийн даатгал	364,079.00	378,374.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,742,777.00	3,860,299.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,763,765.00	30,353,082.00
210301	Гэрэл, цахилгаан	1,588,665.00	1,798,332.00
210302	Түлш, халаалт	26,175,100.00	28,404,750.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,178,578.00	6,456,613.00
210401	Бичиг хэрэг	2,268,950.00	1,018,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,642,200.00	1,637,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	876,260.00	1,189,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	35,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	387,806.00	95,132.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,491,700.00	2,111,381.00
210408	Бараа материал акталсны зардал	511,662.00	370,500.00
2105	Нормативт зардал	22,915,000.00	13,633,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	968,900.00	1,195,350.00
210502	Хоол, хүнс	21,946,100.00	12,279,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	159,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,709,600.00	1,001,000.00
210604	Урсгал засвар	1,709,600.00	1,001,000.00
2107	Томилолт, зочны зардал	112,000.00	98,000.00
210702	Дотоод албан томилолт	112,000.00	98,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	224,000.00	588,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	224,000.00	198,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	40,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,025,334.29	10,853,440.51

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	642,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,025,334.29	10,210,940.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,198,474.16	49,445,772.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,253,000.00	24,769,040.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	18,118,170.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,263,000.00	3,550,870.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,990,000.00	3,100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	154,795.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,635.00	00.00
213404	Хөрөнгийн	97,160.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,790,679.16	24,676,732.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,790,679.16	24,676,732.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>71,850,525.02</u>	<u>7,478,478.49</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>71,850,525.02</u>	<u>7,478,478.49</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>339,240,660.00</u>	<u>370,591,022.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>339,240,660.00</u>	<u>370,591,022.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	307,423,100.00	316,069,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	307,423,100.00	316,069,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,360,160.00	21,669,040.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,263,000.00	21,669,040.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	97,160.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,457,400.00	32,852,082.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,457,400.00	32,852,082.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>339,240,660.00</u>	<u>364,826,422.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>339,240,660.00</u>	<u>364,826,422.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>313,042,185.84</u>	<u>315,380,650.00</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,009,610.84	222,848,171.00
210101	Үндсэн цалин	170,861,596.69	181,764,627.00
210102	Нэмэгдэл	25,749,561.21	21,834,855.00
210104	Урамшуулал	15,398,452.94	19,248,689.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,007,294.00	28,311,515.00
210201	Тэтгэврийн даатгал	18,088,358.00	20,159,471.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,122,738.00	2,109,329.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,689,342.00	1,760,011.00
210204	Ажилгүйдлийн даатгал	364,079.00	428,370.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,742,777.00	3,854,334.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,899,765.00	30,353,082.00
210301	Гэрэл, цахилгаан	1,719,965.00	1,798,332.00
210302	Түлш, халаалт	26,179,800.00	28,404,750.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,726,866.00	5,113,532.00
210401	Бичиг хэрэг	557,000.00	605,500.00

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	1,665,000.00	1,491,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	876,260.00	992,700.00
210404	Ном, хэвлэл	60,000.00	858,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	432,806.00	135,132.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,135,800.00	1,030,400.00
2105	Нормативт зардал	35,571,300.00	18,405,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,363,900.00	1,100,300.00
210502	Хоол, хүнс	21,946,100.00	12,279,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,261,300.00	5,025,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,211,000.00	4,175,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,520,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,691,000.00	4,175,000.00
2107	Томилолт, зочны зардал	112,000.00	98,000.00
210702	Дотоод албан томилолт	112,000.00	98,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	224,000.00	817,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	224,000.00	236,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	231,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,280,350.00	5,259,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,360,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,280,350.00	1,899,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,198,474.16	49,445,772.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,253,000.00	24,769,040.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	18,118,170.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,263,000.00	3,550,870.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,990,000.00	3,100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	154,795.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,635.00	00.00
213404	Хөрөнгийн	97,160.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,790,679.16	24,676,732.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,790,679.16	24,676,732.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	5,764,600.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	5,764,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	5,764,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	5,764,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	5,764,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-5,764,600.00
7	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	00.00	00.00
9	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	-------	--

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,236,903,758.83	7,852,093,558.77	1,450,638,463.96	-	10,638,358,853.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,057,608.93		2,057,608.93
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,236,903,758.83	7,852,093,558.77	1,448,580,855.03	-	10,640,416,462.57
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-1,723,855.69	00.00		-1,723,855.69
C07	Тайлант үеийн үр дүн	-152,559,330.22	00.00	23,692,205.94		-128,867,124.28
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,925,265.00	359,276,282.06	-9,978,134.86		410,223,412.20
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,925,265.00	359,276,282.06	-9,978,134.86		410,223,412.20
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,925,265.00	359,276,282.06	-9,978,134.86		410,223,412.20
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	7,478,478.49		7,478,478.49
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,925,265.00	359,276,282.06	-2,499,656.37		417,701,890.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	349,922,900.00	324,245,250.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	349,922,900.00	324,245,250.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	346,805,700.00	321,145,250.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	236,015,600.00	222,848,171.00
210101	Үндсэн цалин	182,213,000.00	181,764,627.00
210102	Нэмэгдэл	24,526,200.00	21,834,855.00
210104	Урамшуулал	29,276,400.00	19,248,689.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,200,100.00	28,311,515.00
210201	Тэтгэврийн даатгал	22,092,400.00	20,159,471.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,287,400.00	2,109,329.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,852,100.00	1,760,011.00
210204	Ажилгүйдлийн даатгал	460,000.00	428,370.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,508,200.00	3,854,334.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,353,000.00	30,353,082.00
210301	Гэрэл, цахилгаан	2,442,700.00	1,798,332.00

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	28,410,300.00	28,404,750.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,132,000.00	5,113,532.00
210401	Бичиг хэрэг	605,500.00	605,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,491,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	992,700.00	992,700.00
210404	Ном, хэвлэл	858,600.00	858,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	135,132.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,031,200.00	1,030,400.00
2105	Нормативт зардал	26,801,300.00	18,405,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,104,700.00	1,100,300.00
210502	Хоол, хүнс	20,671,200.00	12,279,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,025,400.00	5,025,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,679,700.00	9,664,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,500,000.00	5,489,600.00
210604	Урсгал засвар	4,179,700.00	4,175,000.00
2107	Томилолт, зочны зардал	109,400.00	98,000.00
210702	Дотоод албан томилолт	109,400.00	98,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,215,600.00	1,092,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	625,600.00	511,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	231,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5299000.00	5259000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,400,000.00	3,360,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,899,000.00	1,899,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3117200.00	3100000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,117,200.00	3,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,117,200.00	3,100,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	349,922,900.00	324,245,250.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	316,069,900.00	291,393,168.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	316,069,900.00	291,393,168.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,853,000.00	32,852,082.00
132001	Орон нутгийн төсвөөс	33,853,000.00	32,852,082.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18.00	18.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	18.00	18.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	12.00	12.00

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	06.00	06.00
--------	--	-------	-------

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3360160.00	21,669,040.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3360160.00	21,669,040.00
212	ТАТААС	3360160.00	21,669,040.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	3360160.00	21,669,040.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	3360160.00	21,669,040.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3360160.00	21669040.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3360160.00	21,669,040.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		18,118,170.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3263000.00	3,550,870.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	97160.00	00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3360160.00	21669040.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3360160.00	21,669,040.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3263000.00	21,669,040.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	97160.00	00.00
8	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	00.00	00.00
9	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	00.00	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр "Глобал капитал аудит" ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын Цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд Цэцэрлэгийн эрхлэгч Д.Түмэнжаргал нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Б.Өлзийбуян нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалант сумын Цэцэрлэг нь бага насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргэх зорилго зорилтыг хангах үүднээс сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Жаргалант сумын Цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 67 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөж байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын алба байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 331,141.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,967.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,725.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 4,090.4 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 418,097.7 мянган төгрөг болж өмнөх оноос 7,478.5 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	43,092.8	55,017.6	11,924.8
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	18.5	18.5	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	43,074.3	54,999.1	11,924.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	367,526.5	363,080.1	(4,446.3)
Үндсэн хөрөнгө	407,662.7	413,427.3	5,764.6
Хуримтлагдсан элэгдэл	(40,136.2)	(50,347.2)	(10,210.9)
Нийт хөрөнгө	410,619.2	418,097.7	7,478.5
Өр төлбөр	395.8	395.8	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	410,223.4	417,701.9	7,478.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	410,619.2	418,097.7	7,478.5

Бараа материалын дансны үлдэгдэл 54,999.1 мянган төгрөг болж 11,924.8 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 5,145.7 мянган төгрөг, бичиг хэргийн материал 1,630.5 мянган төгрөг, барилгын засварын материал 3,174.0 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 413,427.3 мянган төгрөг болж 5,764.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 5,764.6 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж худалдаж авсантай холбоотой байна.

Өглөг дансанд 395.8 мянган төгрөгийн үлдэгдэл байгаа нь өмнөх оноос дамжиж ирсэн өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 417,701.9 мянган төгрөг болж өмнөх оноос 7,478.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 21,669.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 552,055.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 552,055.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 164,070.4 мянган төгрөгөөр бууруулж 387,984.6 мянган төгрөгөөр батлагдсан ба аймгийн Засаг даргын 2021.05.06-ний А/289 тоот, 2021.12.06-ны А/742 тоот захирамжуудаар төсвийн зохицуулалт хийгдэж 349,922.9 мянган төгрөгийн төсөв авч зарцуулахаар батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 349,922.9 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 316,069.9 мянга, орон нутгийн төсвөөс 33,853.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 316,069.9 мянга, орон нутгийн төсвөөс 32,852.8 мянга нийт 348,922.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 324,245.2 мянган төгрөгийг зарцуулж 24,676.7 мянган төгрөг буюу 7.1 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 1,000.9 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 324,245.2 мянган төгрөг буюу 92,7 хувьтай байгаа нь нормативд зардлыг 8,396.2 мянган төгрөг, цалингийн зардлыг 13,167.4 мянган төгрөг, тогтмол зардлыг 999.9 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид 21,669.0 мянган төгрөгийг зохих журмын дагуу зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Глобал аудит” ХХК –ний аудитор С.Сарантуяа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилт 31 ажил төлөвлөснөөс биелэлт 95 хувьтай хэрэгжсэн гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 363,589.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 32,275.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь хангамж, бараа материалын зардал, нормативд зардал буурсан, цалин, НДШ-ийн зардлууд өссөн үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааны тайлбарын мянган төгрөгийн сар бүрийн мэдээг 9 удаа, хагас, бүтэн жилийнхийг тус бүр 1 удаа, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн мэдээг 8 удаа, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийн 29,914.4 мянган төгрөгийн үнийн дүнтэй 1 мэдээлэл,

Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн 99,723.7 мянган төгрөгийн 1 мэдээлэл, нийт 129,638.1 мянган төгрөгийн 21 мэдээг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төлөвлөгөөгөөр 35,747.6 мянган төгрөг батлагдсан ба батлагдсан төсвийн 20 хувь нь 7,149.5 мянган төгрөг байна. Төсвийн зохицуулалтаар 31,353.0 мянган төгрөг болж 4,394.6 мянган төгрөг хасагдсан ба төсвийн гүйцэтгэлээр 999.9 мянган төгрөгийн, нийт 5,394.5 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байгаа нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 69,918.8 мянган төгрөгийн хүүхдийн хоол худалдан авах ажиллагааг сумын ЗДТГ зохион байгуулсан байна. Халаалтын 30,304.9 мянган төгрөгийн ажлын шууд гэрээ байгуулсан.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан, Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн зөрчлийг арилгах 1 зөвлөмж өгсний хэрэгжилтийг 2021.05.24-ний №17 дугаар бүхий албан тоотоор ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах 2 заалт бүхий зөвлөмж өгөв.

4.1 Зөвлөмж

4.1.1. Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс нийт 129,638.1 мянган төгрөгийн 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар 6.3.2.төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт, 6.3.6.хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл; гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлж байх түүнд удирдлагаас тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авах

4.1.2. Тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төлөвлөгөөгөөр 35,747.6 мянган төгрөг батлагдсан ба батлагдсан төсвийн 20 хувь нь 7,149.5 мянган төгрөг байна. Төсвийн зохицуулалтаар 31,353.0 мянган төгрөг болж 4,394.6 мянган төгрөг хасагдсан ба төсвийн гүйцэтгэлээр 999.9 мянган төгрөгийн, нийт 5,394.5 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Байгууллагын удирдлага цаашид дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сумын Цэцэрлэг	2	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	2	

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

_____оОо_____